



**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛЖСӨН БАЙГУУЛЛАГЫН  
ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН  
XV ХАВСРАЛТЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Тогтвортой, нэгдмэл гадаад бодлогын хүрээнд 4.5-д “Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.” гэж, 4.5.6-д “Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.” гэж тус тус заасны дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон батлах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцод 1970 оны 03 дугаар сарын 03-ны өдөр нэгдэн орсон. Тус конвенцод Монгол Улсыг нэгдэн орох үед Дэлхийн оюуны өмчийн байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын статусгүй байсан бөгөөд 1974 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтаар төрөлжсөн байгууллагын статустай болжээ.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтад төрөлжсөн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглахаар импортлох буюу экспортлох эд зүйлсийн хувьд шууд татвар, гаалийн татвар болон импорт, экспортын хязгаарлалтаас чөлөөлөх, тухайн байгууллагын чиг үүргийн хүрээнд албан тушаалын дагуу хэлсэн, бичсэн үг, үйлдлийн хувьд эрх зүйн ажиллагаанаас чөлөөлөх, тухайн байгууллагын эд хөрөнгө халдашгүй байх зэрэг эрх ямба, дархан эрх багтдаг байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын оролцогч улс хэдий ч түүний хавсралт XV болох Дэлхийн оюуны өмчийн байгууллагын эрх, ямба, дархан эрхийг зохицуулж буй уг хавсралтыг соёрхон батлаагүй байна.

Түүнчлэн Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1979 онд гишүүнээр элссэн бөгөөд түүнээс хойш тус байгууллагын удирдан хэрэгжүүлдэг нийт 26 гэрээ хэлэлцээрийн 16-д нэгдэн орж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын статустай уг олон улсын байгууллагатай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар нь Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтийг хангах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, албан хаагчдыг сургах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж ирсэн.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын гишүүн улсын хувьд хууль зүйн үүргээ биелүүлэх шаардлагатайгаас гадна Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гишүүнээр элссэн нөхцөл байдал нь түүнд хамаарах нэмэлтийг соёрхон батлах зайлшгүй хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралт нь Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ” гэж заасан олон улсын гэрээ тул заавал соёрхон батлах шаардлагатай.

#### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлах тухай заалт байхаар боловсруулна.

#### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын гишүүн улсын хувьд хууль зүйн үүргээ биелүүлэхийн сацуу Дэлхийн оюуны өмчийн байгууллагын төлөөлөгч, шинжээчид Монгол Улсад албаны чиг үүргээ тайван гүйцэтгэх баталгаа бий болсноор хамтын ажиллагааг илүү өргөжүүлэн хөгжүүлэх, тус байгууллагын албан ёсны төлөөлөгчдийг хүлээн авч, хамтран ажиллахад эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн, тус байгууллагын төлөөлөгчийн газар, нэгжийг нээн ажиллуулахад тавигддаг анхан шатны шаардлага хангагдах бөгөөд цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд тус байгууллагын төлөөлөгчийн газар, нэгжийг Монгол Улсад нээн ажиллуулах суурь нөхцөл бүрдэнэ.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 14.4-д “Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах;” гэж заасантай бүрэн нийцнэ.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагын төлөөлөгч, шинжээч нарт олгох эрх ямба, дархан эрх нь тэднийг зөвхөн Монгол Улсад айлчлал хийх буюу богино хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх тул нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар үүсэхгүй болно.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.